



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/249-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: [baasansurens@audit.gov.mn](mailto:baasansurens@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын газрын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.Аудитын тайлан .....	14
3.1 Ерөнхий зүйл .....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4. Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	18
3.8 Аудитын гол асуудал.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт .....	20
4.1 Залруулсан алдаа .....	20
4.2 Зөвлөмж .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	21

---

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БГАУ</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ТӨБЗГ</b>	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
<b>УСНББОУС</b>	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ХХҮЕГ</b>	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.16 № СЭА-2022/249-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,343,560.00</b>	<b>21,627,413.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>21,343,560.00</b>	<b>21,627,413.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>21,343,560.00</b>	<b>21,627,413.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,350,000.00	186,100.00
35420	Аж ахуйн материал	2,359,090.00	2,564,090.00
35450	Барилгын засварын материал	313,500.00	313,500.00
35470	Бусад хангамжийн материал	17,320,970.00	18,563,723.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,526,803,333.46</b>	<b>1,577,945,930.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,526,803,333.46</b>	<b>1,577,945,930.35</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,455,606,167.80</b>	<b>1,508,373,764.73</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,460,348,486.86	1,543,030,129.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(111,928,650.79)	(151,621,786.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,733,000.00	187,733,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(169,095,499.88)	(187,733,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	263,030,451.07	247,230,360.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(208,399,297.07)	(185,375,622.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,993,855.00	137,245,717.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(78,076,177.39)	(82,135,033.69)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>71,197,165.66</b>	<b>69,572,165.62</b>
39301	Программ хангамж	8,456,900.00	7,655,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,227,734.34)	(3,050,834.38)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,968,000.00	64,968,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,548,146,893.46</b>	<b>1,599,573,343.35</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,548,146,893.46</b>	<b>1,599,573,343.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,548,146,893.46</b>	<b>1,599,573,343.35</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	64,968,000.00	64,968,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,483,178,893.46</b>	<b>1,534,605,343.35</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,547,590,169.80	1,483,178,893.46
51220	Тайлант үеийн үр дүн	(64,411,276.34)	51,426,449.89
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,548,146,893.46</b>	<b>1,599,573,343.35</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,220,899,779.00</b>	<b>1,080,567,162.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>175,243,579.00</b>	<b>141,875,062.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>175,243,579.00</b>	<b>141,875,062.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>129,075,500.00</b>	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	129,075,500.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,837,079.00	141,207,060.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,331,000.00	668,002.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,045,656,200.00</b>	<b>938,692,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,030,459,200.00</b>	<b>930,807,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,030,459,200.00	930,807,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,197,000.00</b>	<b>7,885,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,197,000.00	4,885,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	3,000,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,279,253,169.87</b>	<b>1,029,140,712.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,279,253,169.87</b>	<b>1,029,140,712.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,182,752,459.93</b>	<b>1,008,731,792.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>721,630,977.56</b>	<b>708,856,663.50</b>
210101	Үндсэн цалин	562,067,944.46	526,539,462.32
210102	Нэмэгдэл	118,394,662.70	114,619,961.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,526,860.00	21,990,755.80
210104	Урамшуулал	24,641,510.40	45,706,484.04
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>93,309,849.49</b>	<b>95,519,507.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	65,077,620.32	69,572,672.70
210202	Тэтгэмжийн даатгал	7,629,822.58	7,554,060.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,794,738.04	5,609,807.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,346,151.73	1,299,204.77
210205	Эрүүл мэндийн даатгал	13,461,516.82	11,483,761.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>101,580,329.00</b>	<b>76,889,530.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,611,799.00	3,937,111.00
210302	Түлш, халаалт	86,127,795.00	69,425,759.00
210303	Цэвэр, бохир ус	7,840,735.00	3,526,660.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,556,520.77</b>	<b>17,283,819.00</b>
210401	Бичиг хэрэг	8,754,630.00	8,816,029.00
210402	Тээвэр, шатахуун	3,588,200.00	2,158,900.00

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,331,880.00	2,916,710.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,600.00	150,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,533,680.00	3,241,380.00
210408	Бараа материал акталсны зардал	16,098,530.77	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,805,486.00</b>	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	252,400.00	-
210502	Хоол, хүнс	40,553,086.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,683,400.00</b>	<b>18,519,300.00</b>
210604	Урсгал засвар	4,683,400.00	18,519,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>310,200.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	310,200.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>89,914,158.01</b>	<b>1,598,510.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,653,513.01	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,612,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,928.00	143,838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	235,000.00	1,190,000.00
210807	Газрын төлбөр	54,142.00	49,897.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>94,961,539.10</b>	<b>90,064,463.11</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,200.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,247,339.10	90,064,463.11
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>96,500,709.94</b>	<b>20,408,919.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,081,500.00</b>	<b>1,000,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,431,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,650,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>87,819,209.94</b>	<b>19,408,919.12</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,819,209.94	19,408,919.12
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>600,000.00</b>	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	600,000.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(58,353,390.87)</b>	<b>51,426,449.89</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,057,885.47</b>	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	6,057,885.47	-
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(64,411,276.34)</b>	<b>51,426,449.89</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,174,731,700.00</b>	<b>938,692,100.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>129,075,500.00</b>	<b>0.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>129,075,500.00</b>	<b>0.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>129,075,500.00</b>	<b>0.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	129,075,500.00	0.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,045,656,200.00</b>	<b>938,692,100.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,030,459,200.00</b>	<b>930,807,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,030,459,200.00	930,807,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,197,000.00</b>	<b>7,885,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,197,000.00	4,885,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	3,000,000.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,174,731,700.00</b>	<b>938,692,100.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,174,731,700.00</b>	<b>938,692,100.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,078,230,990.06</b>	<b>918,283,180.88</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>720,279,456.74</b>	<b>708,856,663.50</b>
210101	Үндсэн цалин	545,581,261.43	526,539,462.32
210102	Нэмэгдэл	118,650,307.11	114,619,961.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,526,860.00	21,990,755.80
210104	Урамшуулал	39,521,028.20	45,706,484.04
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>94,661,370.31</b>	<b>95,519,507.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,614,279.42	68,064,387.75
210202	Тэтгэмжийн даатгал	7,583,488.67	7,554,060.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,754,310.90	5,609,807.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,337,208.34	1,299,204.77
210205	Эрүүл мэндийн даатгал	13,372,082.98	12,992,046.70
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>101,580,329.00</b>	<b>76,889,530.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,611,799.00	3,937,111.00
210302	Түлш, халаалт	86,127,795.00	69,425,759.00
210303	Цэвэр, бохир ус	7,840,735.00	3,526,660.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,173,190.00</b>	<b>16,917,770.00</b>
210401	Бичиг хэрэг	9,841,900.00	7,540,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,342,200.00	2,158,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,413,710.00	2,994,710.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,600.00	150,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,325,780.00	4,073,260.00

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,105,486.00</b>	<b>0.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	252,400.00	0.00
210502	Хоол, хүнс	40,553,086.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,189,800.00</b>	<b>18,501,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	119,900.00	0.00
210604	Урсгал засвар	5,069,900.00	18,501,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>310,200.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	310,200.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>89,931,158.01</b>	<b>1,598,510.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,653,513.01	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,612,800.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,928.00	143,838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	252,000.00	1,190,000.00
210807	Газрын төлбөр	54,142.00	49,897.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,000,000.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>96,500,709.94</b>	<b>20,408,919.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,081,500.00</b>	<b>1,000,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,431,500.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,650,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>87,819,209.94</b>	<b>19,408,919.12</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	87,819,209.94	19,408,919.12
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>600,000.00</b>	<b>0.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	600,000.00	0.00



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	Хувиар
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-	-
71902	Нийгмийн халамж	1,124,007,100.00	930,807,100.00	193,200,000.00	82.81
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	929,806,700.00	929,806,700.00	(0.00)	100.00
12	Татварын бус орлого	929,806,700.00	929,806,700.00	0.00	99.99
122	Тусламж, санхүүжилтийн орлого	929,806,700.00	929,806,700.00	0.00	99.99
122005	Төсвөөс санхүүжих	929,806,700.00	929,806,700.00	0.00	99.99
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	929,806,700.00	929,806,700.00	(0.00)	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	929,806,700.00	910,398,180.88	19,408,519.12	97.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	929,806,700.00	910,398,180.88	19,408,519.12	97.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	711,011,800.00	708,856,663.50	2,155,136.50	99.69
210101	Үндсэн цалин	558,304,100.00	526,539,462.32	31,764,637.68	94.31
210102	Нэмэгдэл	131,589,500.00	114,619,961.34	16,969,538.66	87.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,118,200.00	21,990,755.80	(872,555.80)	104.13
210104	Урамшуулал	-	45,706,484.04	(45,706,484.04)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,791,500.00	95,519,507.38	1,271,992.62	98.68
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	68,631,100.00	68,064,387.75	566,712.25	99.17
210202	Тэтгэмжийн даатгал	7,540,100.00	7,554,060.19	(13,960.19)	100.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,032,100.00	5,609,807.97	422,292.03	92.99
210204	Ажилгүйдлийн даатгал	1,508,000.00	1,299,204.77	208,795.23	86.15
210205	Эрүүл мэндийн даатгал	13,080,200.00	12,992,046.70	88,153.30	99.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,193,900.00	76,889,530.00	12,304,370.00	86.20
210301	Гэрэл, цахилгаан	5,564,600.00	3,937,111.00	1,627,489.00	70.75
210302	Түлш, халаалт	78,156,600.00	69,425,759.00	8,730,841.00	88.82
210303	Цэвэр, бохир ус	5,472,700.00	3,526,660.00	1,946,040.00	64.44
2104	Хангамж, бараа материалын зардал	13,761,800.00	13,032,770.00	729,030.00	94.70
210401	Бичиг хэрэг	4,687,100.00	4,680,100.00	7,000.00	99.85
210402	Тээвэр, шатахуун	1,773,900.00	1,773,900.00	(0.00)	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,973,000.00	2,354,710.00	618,290.00	79.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	251,800.00	150,800.00	101,000.00	59.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,076,000.00	4,073,260.00	2,740.00	99.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,681,300.00	15,501,200.00	2,180,100.00	87.67
210601	Багаж, техник хэрэгсэл	2,174,900.00	-	2,174,900.00	-
210604	Урсгал засвар	15,506,400.00	15,501,200.00	5,200.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	236,600.00	-	236,600.00	-
210702	Дотоод албан томилолт	236,600.00	-	236,600.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,129,800.00	598,510.00	531,290.00	52.97
210803	Даатгалын үйлчилгээ	396,000.00	170,775.00	225,225.00	43.12
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	143,838.00	16,162.00	89.89
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	69,300.00	44,000.00	25,300.00	63.49
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,500.00	190,000.00	215,500.00	46.85

**Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210807	Газрын төлбөр	99,000.00	49,897.00	49,103.00	50.40
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,408,519.12	(19,408,519.12)	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	19,408,519.12	(19,408,519.12)	-
<b>80103</b>	<b>Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ</b>	<b>193,200,000.00</b>	-	<b>193,200,000.00</b>	-
12	Татварын бус орлого	193,200,000.00	-	193,200,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	193,200,000.00	-	193,200,000.00	-
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/	193,200,000.00	-	193,200,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	193,200,000.00	-	193,200,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	193,200,000.00	-	193,200,000.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	193,200,000.00	-	193,200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,375,400.00	-	1,375,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,375,400.00	-	1,375,400.00	-
2105	Нормативт зардал	65,147,000.00	-	65,147,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,697,000.00	-	1,697,000.00	-
210502	Хоол, хүнс	60,480,000.00	-	60,480,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,970,000.00	-	2,970,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	126,677,600.00	-	126,677,600.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,677,600.00	-	126,677,600.00	-
<b>80802</b>	<b>Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг</b>	<b>1,000,400.00</b>	<b>1,000,400.00</b>	-	<b>100.00</b>
12	Татварын бус орлого	1,000,400.00	1,000,400.00	-	100.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	1,000,400.00	1,000,400.00	-	100.00
122005	Төсвөөс санхүүжих	1,000,400.00	1,000,400.00	-	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,400.00	1,000,400.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,400.00	1,000,000.00	400.00	99.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,400.00	1,000,000.00	400.00	99.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,400.00	1,000,000.00	400.00	99.96
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,400.00	1,000,000.00	400.00	99.96
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	400.00	(400.00)	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	400.00	(400.00)	-
<b>12000</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлан оны гүйцэтгэл
<b>11000</b>	<b>Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	-	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,400,000.00	2,885,000.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	(115,000.00)
300008	Гадаад орон, олон улсын байгууллага дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл	-	(115,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,400,000.00	3,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,400,000.00	3,000,000.00
<b>71902</b>	<b>Нийгмийн халамж</b>	<b>10,597,000.00</b>	<b>7,885,000.00</b>
<b>80101</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>8,197,000.00</b>	<b>7,885,000.00</b>
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,197,000.00	7,885,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,197,000.00	7,885,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,197,000.00	7,885,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,197,000.00	3,885,000.00
210401	Бичиг хэрэг	6,370,000.00	2,860,000.00
210402	Тээвэр, шатахуун	887,000.00	385,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	940,000.00	640,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,000,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.00	5,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	10,000,000.00	5,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,400,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,400,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	-
<b>12000</b>	<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

/төгрөгөөр/

### 3.Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын / цаашид Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар гэх / 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим системд шивэгдээгүй, нотлох дэмжих боломжгүй бараа материалын худалдан авалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчныг бий болгож амьжиргааны түвшнийг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний талаарх төрийн бодлогыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд сангийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд ХХҮЕГ-аас дотоод хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд тус газрын “Дотоод хяналт шалгалтын комисс” нь 2021 оны 12 дугаар сард дотоод хяналт шалгалт хийж, зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал


Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 475,665.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,134.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4,994.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,426.5 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.



Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	21,343.5	21,627.4	283.9
Үндсэн хөрөнгө	1,526,803.3	1,577,945.9	51,142.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,548,146.8</b>	<b>1,599,573.3</b>	<b>51,426.5</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,548,146.8	1,599,573.3	51,426.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,548,146.8</b>	<b>1,599,573.3</b>	<b>51,426.5</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 21,627.4 мянган төгрөг болж 283.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн санхүүжилтээр нийт 31,210.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Швейцарын хөгжлийн агентлаг, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-өөс 668.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, нийт 31,594.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,187,862.2 мянган төгрөг болж өмнөх оноос 91,331.5 мянган төгрөгөөр өссөн нь 141,207.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, ТӨБЗГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А-1/825, ХХҮЕГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/552 дугаар тушаалын дагуу 37 нэр төрлийн 49,875.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Тайлант онд Азийн хөгжлийн банкны 82,681.6 мянган төгрөгийн хандиваар конторын барилгын 1 дүгээр давхарт их засвар хийгдсэн бөгөөд Азийн хөгжлийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг, аймгийн Ахмадын хорооны хандиваар нийт **59,183.4** мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,599,573.3 мянган төгрөг болж 51,426.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь өмнөх оноос 140,332.6 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар буурсан байна. Энэ нь коронавируст

халдвар /Ковид-19/ -ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг сунгагдсантай холбоотойгоор тус газрын дэргэдэх Сүхбаатар сумын Ахмадын сувиллын үйл ажиллагааг тайлант хугацаанд түр хааснаас голлон шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь өмнөх оноос 250,112.4 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар буурсан нь Баянгол, Мандал сумдын Ахмадын сувиллыг сумын Засаг даргын харьяанд шилжүүлснээр сувиллын газруудын тогтмол зардал буурснаас голлон шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 1,248,504.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 25,330.0 мянган төгрөгөөр бууруулж 1,223,174.0 мянган төгрөгөөр баталсан бол 2021 оны 12 дугаар сард батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, 99,166.9 мянган төгрөгөөр бууруулан 1,124,007.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр /Үндсэн үйл ажиллагаа, Сүхбаатар сумын Ахмадын сувилал/ -ийг санхүүжүүлэхээр 1,124,007.1 мянган төгрөгийн төсөв баталж, **930,807.1** мянган төгрөгийг улсын төсвөөс, 193,200.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 930,807.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт урсгал зардалд **911,398.2** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 19,408.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 911,398.2 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 2,155.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 1,271.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,304.4 мянган төгрөг, хангамжийн материалын зардал 729.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал зардлын зардал 2,180.1 мянган төгрөг, томилолтын зардал 236.6 мянган төгрөг, БГАҮ-ний зардал 531.3 мянган төгрөг зэрэг нийт **19,408.9** мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Халамжийн сангаас “Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа”-ны ажлын санхүүжилт 5,000.0 мянган төгрөг, Мобиком корпораци ХХК-иас байрны түрээсийн төлбөрийн 3,750.0 мянган төгрөг, Халамжийн сангийн “Хүнсний эрхийн бичгээр иргэдэд үйлчлэх хүнсний дэлгүүр”-ийн сонгон шалгаруулалтын цахим тендерийн хураамж 1,190.0 мянган төгрөг зэрэг нийт 9,940.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Зарцуулалтыг дэлгэрэнгүй байдлаар авч үзвэл:

- Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны ажлын зардалд бичиг хэргийн зардалд 2,860.0 мянган төгрөг, E work программ /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбарын албан хэрэгцээнд ашиглаж байгаа онлайн программ / -ын төлбөрт 1,000.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 640.0 мянган төгрөг, шатахууны зардалд 385.0 мянган төгрөг зэрэг 4,885.0 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 115.0 мянган төгрөгийг Халамжийн санд төвлөрүүлсэн,
- Түрээсийн төлбөрийн орлогын 20 хувь буюу 750.0 мянган төгрөгийг аймгийн төрийн сан дахь хөрөнгө худалдан борлуулсны орлогын дансанд төвлөрүүлж, өөрийн орлогыг зарцуулах эрхийн дагуу конторын барилгын урсгал зардалд 2,051.0 мянган төгрөгийг, авто машины засварт 949.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан,
- Халамжийн сангийн “Хүнсний эрхийн бичгээр иргэдэд үйлчлэх хүнсний дэлгүүр”-ийн тендер зохион байгуулагдахгүй болсон тул оролцогчдод тендерийн хураамж 1,190.0 мянган төгрөгийг буцаан шилжүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

**3.7.1** Тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 82,681.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй их засвар хийгдэж, 19,890.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Ажил мэргэжлийн төв”, Швейцарын хөгжлийн агентлаг, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр 26,326.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төв”-ийн үйл ажиллагааг нээсэн байна.

**3.7.2** Тайлант онд коронавируст халдвар /Ковид-19/ -ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-н хүртэл сунгаж, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарласантай холбоотойгоор Сүхбаатар сумын Ахмадын сувиллын үйл ажиллагааг түр хаасан бол Баянгол, Мандал сумын Ахмадын сувиллыг сумдын Засаг даргын харьяанд шилжүүлсэн байна.

**3.7.3** Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т “ Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох “ гэж заасан боловч тус байгууллагын 2021 оны төсөвт урамшууллын зардалд хөрөнгө төлөвлөөгүйгээс албан хаагчдын урамшууллын зардлыг үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлаас санхүүжүүлсэн

байна. Цаашид улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардлыг төсөвт тусгаж, санхүүжүүлж байх нь зүйтэй юм.

**3.7.4** Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 89,536.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 92 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын тайлант оны үйл ажиллагаанд **930,807.1** мянган төгрөгийн / Сүхбаатар сумын Ахмадын сувилал үйл ажиллагаа явуулаагүй учир өөрийн орлого ороогүй / төсөв батлагдаж, гүйцэтгэлээр **911,398.2** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.1 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.


### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,771.8 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, шилэн дансны цахим хуудаст 49 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	4,771.8	2	4,771.8	100.0
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>4,771.8</b>	<b>3</b>	<b>4,771.8</b>	<b>100.0</b>



### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **100,331.9** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 96,202.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,129.3 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн 82,681.6 мянган төгрөгийн өртөг бүхий их засварын ажлыг капиталжуулаагүй, санхүүгийн байдлын тайлан болон үндсэн хөрөнгийн тодруулга тайланд дутуу тайлагнасныг залруулга хийлгэв.
- Урсгал засварын зардлаас 0003 СББ улсын дугаар бүхий Land Cruiser 200 маркийн авто машины засвар, сэлбэг хэрэгсэлд 10,108.5 мянган төгрөг / Мөнххада ХХК-д 6,034 мянган төгрөг, Эй Ар Би монголия ХХК-д 2,700.0 мянган төгрөг, Солонго солюшинс ХХК-д 594.0 мянган төгрөг, Хүүхдийн мөрт ХХК-д 111.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас Хүүхдийн мөрт ХХК-д 469.0 мянган төгрөг, Сорхагтани ХХК-д 200.0 мянган төгрөг /, 7766 СЭҮ улсын дугаар бүхий Хьюндай элантра маркийн авто машины сэлбэг засвар, сэлбэг хэрэгсэлд 3,412.5 мянган төгрөг /Монгол Хьюндай автомотив ХХК-д 3,132.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас Мандахбаатар ХХК-д 280.0 мянган төгрөг/ зэрэг нийт **13,521.0** мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийснийг “Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг”-т нөхөж бичүүлэв.

## 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 4,129.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	3	100,331.9	2	96,202.6					1	4,129.3